

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ
/2023.05.25-2023.06.25/

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг "Нэгдүгээрт хүүхэд" уриан дор 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр сумандаа зохион байгуулсан бөгөөд тус үйл ажиллагааг Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, 3-р цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, Илчлэг шивээ ААТҮГ, Цагдаагийн хэсэг, Эрүүл мэндийн төв нар хамтран зохион байгууллаа.

Мөн тус арга хэмжээний үеэр Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газраас:

- Соёлын төв
- 3-р цэцэрлэг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
- Ахмадын хороо зэрэгт шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг гардуулан өгөв.




Мөн энэ онд сумын хэмжээнд “Алдарт эх”-ийн хоёрдугаар зэргийн одон 11 ээж, “Алдарт эх”-ийн нэгдүгээр зэргийн одонгоор 1 ээж энгэрээ мялаалаа.



Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах тухай” А/68 тоот захирамжийн хүрээнд төрийн байгууллагуудаар хяналт шалгалтын ажил хийгдлээ. Тус ажлын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд

хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/150 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” зэрэг үндэслэлээр хянан шалгаж, зөвлөмжийг хүргүүлээд байна.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулалтыг зохион байгуулахтай холбогдуулан “Бэлэн бай” аяныг санаачлан хэрэгжүүлж байгаа бөгөөд тус аянд сумын бүх төрийн болон төрийн бус байгууллага, ААН, иргэд нэгдээд байна. “Бэлэн бай” аяны хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу иргэдэд газар хөдлөлтийн аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах талаар ойлголт, мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх юм.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Монгол улсын шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газраас хамтран Монгол улсын хэмжээнд зохион байгуулж буй Газар хөдлөлтийн Стратегийн команд штабын дадлага сургууль 06

дугаар сарын 08 ны өдрийн 16:00 минутад Зарлан мэдээллийн дуут **ДОХИО** - оор эхлэв. Сумын хэмжээнд иргэд түр цугларах цэгийн байршлыг 5 цэгээр тодорхойлон, тогтоосон цэг тус бүрт сумын Онцгой комисс болон мэргэжлийн анги ажиллаа. Түр цугларах 5 цэгт нийт 1175 иргэн цугларав.



"Нээлттэй шүүх" өдөрлөг зохион байгууллаа. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/45 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд Говьсүмбэр аймаг дахь шүүхийн Тамгын газраас 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр сумын иргэдэд "Нээлттэй шүүх" өдөрлөгийг зохион байгууллаа.

Тус өдөрлөгөөр шүүхийн үйл ажиллагаа онцлог, бүтэц, зохион байгуулалтын талаар болон шүүхийн эвлэрүүлэн зуучлалд хэрхэн хандах асуудлаар мэдээлэл өгч ажиллалаа.



2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгууль нь сумын Засаг даргын Тамгын газрын байранд 1, 2-р хэсгийн хороогоор санал авах үйл ажиллагаа явагдсан. Сумын хэмжээнд 1-р хэсгийн хороонд санал өгөх 1368 сонгогч, 2-р хэсгийн хороонд санал өгөх 713 сонгогч бүртгэлтэй бөгөөд санал авах үйл ажиллагаанд 1-р хэсгийн хорооноос 508, 2-р хэсгийн хорооноос 231 сонгогч саналаа өгсөн байна.



Тулгар төрийн 2232, Их Монгол улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн сумын үндэсний их баяр наадам 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдахаар товлогдоод байна. Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 19-ний А/94 тоот захирамжаар баяр наадам зохион байгуулах хороо болон салбар хороодыг байгуулан бэлтгэл ажлыг ханган ажилласаар байна.

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээг "Гэгээн мандарваа" уламжлалтын эмнэлэгтэй хамтран 2023 оны 06 сарын 12-16-ны өдөр хүртэл сумын байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, ахмад настан нийт 20 иргэнийг хамруулан үйлчилгээ үзүүлсэн байна.



Залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Илчлэг Шивээ" ААТҮГ-аас зохион байгуулсан караоке тэмцээн нь 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр сумын 7 төсвийн байгууллагын 35 албан хаагчдыг хамруулан, оролцоог идэвхжүүлсэн арга хэмжээ зохион байгуулагдлаа.



Монгол улсын засгийн газрын тохируулагч агентлаг "СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР"-аас салбар бүгд стандартын шаардлага хангаагүй бүх хэлбэртэй үл эвлэрэх, стандартыг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, стандарт мөрдөөгүй, зөрчсөн үйлдэлд шаардлага тавих, зөрчлийг цаг алдалгүй арилгуулах, стандартыг салбар бүрд чанд мөрдүүлэх, улмаар олон нийтийн стандартын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх зорилгоор "ЮМАНД ХЭМЖЭЭ БИЙ" үндэсний хэмжээний нөлөөллийн аян зохион байгуулж байна. Тус аянд Шивээговь сумын ЗДТГ-ын албан хаагчид нэгдээд байна.



Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр иргэд дараах үйлчилгээнүүдийг e-mongolia цахим системээс цаг алдалгүй авах боломжтой. 06 дугаар сарын байдлаар нийт 37 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

- Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэл лавлагаа- 8
- Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа-19
- Зээлийн мэдээллийн лавлагаа-1
- Иргэний үнэмлэх лавлагаа-3
- Жолоодох эрхийн оноо лавлагаа-1
- Жолоочийн лавлагаа мэдээлэл-1
- Дээд боловсролын байгуулгын дипломын тодорхойлолт-4



ОНХС-ийн талаар

ОНХС-аар хийгдэх “Хогны машин худалдан авах” ГСАШГСЗДТГ/202304008 дугаартай ажил, “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ нүүрс тээврийн автомашин худалдан авах” ГСАШГСЗДТГ/202304010 ажлыг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2023 оны 06 сарын 05-ний өдөр нээсэн. Хогны машин худалдан авах тендерт 3 компани, “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ нүүрс тээврийн автомашин худалдан авах” тендерт 1 компани үнийн санал ирүүлсэн бөгөөд тендерийн бичиг баримттай танилцаж үр дүнг нийтлэхээр бэлтгээд байна.

Сумын Засаг даргын А/77 дугаартай “Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил”, Засаг даргын А/78 дугаартай “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил”-ын үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгийг бүрдүүлэн, 2023 оны 06 сарын 15-ны өдөр тендерүүдийг зарлаад байна.

Хөрөнгө оруулалтын ажил болон ОНХС-ийн цахим санал асуулгыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхээр сумын албан ёсны цахим хуудас “Шивээговь сумын мэдээ” хаягаар ОНХС-ийн цахим саналын мэдээ мэдээллийг тогтмол нийтэлж, зар мэдээг түгээн ажиллаж байна. 06 дугаар сарын 23-ны байдлаар цахим болон цаасан санал сумын хэмжээнд 1-р баг 792 санал, 2-р баг 156 саналтайгаар тус тус явагдаж байна.



Төсөв, төрийн сангийн талаар

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу оруулж байна.

Мөн сар бүр:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)

- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

Тухай бүр:

- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээ тайланг тайлагнаж байна.

Сумын Засаг даргын тамгын газарт татварын пос машинаар иргэдэд үйлчилж, татварыг цахимаар бүрдүүлж байна. Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 14 хоногийн байдлаар 11 төрлийн татварын орлого бүрдээд байна. ОН-ын татварын орлого гүйцэтгэлээр 27,319,363.67 төгрөг бүрдсэн байна.

Хагас жилийн байдлаар дараах татварын орлогуудыг төвлөрүүлээд байна.

№	Татварын төрөл	/1-5-р сарын байдлаар/			2023.05.31	
		Жилийн батлагдсан төлөвлөгөө	Төлөвлөгөө өссөн дүнгээр	Гүйцэтгэл өссөн дүнгээр	Биелэл дүнгээр	Биелэлт хувиар
1	ЦХБТАОА Татвар	1,707,993,400	756,950,000	691,108,552.38	65,841,447.62	91
2	Үйл ажиллагааны ОАТ	10,000,000	4,150,000	1,024,003.25	3,125,996.75	25
3	Суутгагчийн ОАТ	-	-	1,900,600	(1,900,600)	#DIV/0!
4	Иргэний эрх борлуулсны орлого АТ	-	-	85,560	(85,560)	#DIV/0!
5	Малын тоо толгойн АТ	30,000,000	12,500,000	3,302,100	9,197,900	26
6	Үл хөдлөх эд хөрөнгийн АТ	297,000,000	99,000,000	118,877,565.26	(19,877,565.26)	120
7	Галт зэвсэг/ бууны/ АТ	1,070,000	450,000	60,000.00	390,000	13
8	Газрын үл хөдлөх эд хөрөнгийн АТ	-	-	47,002	(47,002)	#DIV/0!
9	Иргэний ҮХЭХАТ	-	-	30,000.00	(30,000.00)	#DIV/0!
10	Улсын тэмдэгийн хураамж	3,000,000	1,250,000	328,691	921,309	26
11	Газрын төлбөр	171,680,000	57,200,000	20,223,262.60	36,976,737.40	35
12	Хог хаягдлын хураамж	18,000,000	7,500,000	2,205,000	5,295,000	29
13	Түгээмэл тархцтай АМНАТ	3,000,000	1,250,000	15,387,500	(14,137,500)	1,231
14	Иргэний ҮХЭХАТ	5,000,000	8,300,000	12,164,000	(3,864,000)	147
15	Хадгаламж-н хүүгийн орлого	20,000,000	2,075,000	8,454,802.44	(6,379,802.44)	407
Нийт дүн		2,266,743,400	950,625,000	875,198,638.67	75,426,361.33	92

Хөдөө аж ахуйн талаар

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн А/159 дүгээр “Комисс томилох тухай” захирамж, Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29 -ны өдрийн захирамжийг тус тус үндэслэн 2023 оны 05 сарын 30-аас 06-р сарын 06-ны өдөр хүртэл ажлын хэсгийн хамт хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж 1, 2 дугаар багийн малчин мал бүхий 36 өрхийн нийт 14103 мал тоологдсон байна. Үүнд: Тэмээ- 202 Адуу- 629 Үхэр- 767 Хонь- 6787 Ямаа- 5718



2023 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Хоршоо хөгжүүлэх санд анхаарал хандуулах ангилалд багтсан зээлдэгч Д-тэй уулзаж 224,000 төгрөгийг төлүүлээд байна. Мөн муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгч А-тай ШШГЕ газрын шийдвэр гүйцэтгэгчтэй хамтран очиж уулзан 884,000 төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансанд тус тус тушаалгасан байна.

Сумын нутаг дэвсгэрт бог малын мялзан өвчин ихээр гарсан тул мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн малыг булж устган, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийгээд байна. Хөдөөгийн багийн малчин иргэдэд өвчний шинж тэмдэг илрэх, мал амьтан үхэж үрэгдсэн тохиолдлыг мал эмнэлгийн эмчид мэдэгдэх, булж устгуулах, ариутгал хийлгэх зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүр өгч ажиллаад байна. Суманд гарсан бог малын мялзан өвчний сүүлийн тохиолдолын устгалд 2023 оны 6 сарын 10-ны өдөр Говьсүмбэр аймгийн мал эмнэлгийн ажлын албатай 2 өрхийн 7 өвчтэй малыг ариутгал халдваргүйжүүлэлт хийж нүхэнд булж устган ажилласан.



Мөн мялзан өвчинтэй холбоотойгоор аймгийн мал эмнэлгийн газрын улсын байцаагчийн хамтаар 2023 оны 6 сарын 15 өдөр “Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн хүрээнд сумын мал нядалгааны газар болон махны лангууг лацаддаж үйл ажиллагааг нь түр зогсоох арга хэмжээ авч ажиллаж байна.

Боловсролын талаар

2023 оны 06 дугаар сарын 05-09-ны хооронд 9,12-р ангийн суралцагчдын төгсөх шалгалт улсын хэмжээнд зохион байгуулагдав. Тус шалгалтад 68 сурагч шалгуулсан болно.



Дэлхийн банк, БШУЯ, БШУГ, Ерөнхий боловсролын сургуулиуд хамтран хэрэгжүүлж буй "Боловсролын чанарын шинэчлэл" 650 сургуульд 27.0 сая \$-ийн төсөл, хөрөнгө оруулалт хэрэгжсэн. Манай аймагт 19 төсөл 190.0 сая төгрөгийн төсөл ЕБС-дад хэрэгжсэнээс сумын 3 дугаар сургуулийн бага ангийн багш нарын санаачилсан "Технологийн шинэчлэл-оюунлаг ирээдүй" төсөл шилдэг төслөөр шалгараад байна.



2023 оны 6 сарын 15-18-ны өдрүүдэд 8 судлагдахуун хичээлээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 31 суралцагч ЭНШ өгснөөс 4 судлагдахууны дундаж оноо 500с дээш гарсан амжилт үзүүлээд байна.



Цагдаагийн байгууллага

- Хүлээн авч шалгасан гомдол мэдээлэл, хэргийн талаар:

06 дугаар сарын байдлаар гэмт хэргийн 3 гомдол мэдээлэл, зөрчлийн 7 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан.

Үүнээс: Гэмт хэргийн 3 гомдол мэдээллийг хэрэг үүсгэн яллагдагчаар татан сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Зөрчлийн 7 гомдол мэдээллээс 3-г зөрчлийн хэрэг нээж 1 иргэнийг шүүхээр баривчилуулсан. 4 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж нэгжээр торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан.

➤ Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж өөрийн үйлдлийг хянах чадваргүй явсан 22 иргэнийг ар гэр асран хамгаалах хүнд нь хүлээлгэн өгсөн. ЦХ-ийн ЭСББайранд 14 иргэнийг хүлээлгэн өгсөн. МУ-ын ЗТХ-ын заалтуудыг зөрчсөн 22 иргэнийг 475.000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан. АСАП санд шүүгчийн захирамжаар эрэн сурвалжлагдаж байсан 1 иргэнийг олж тогтоон холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгсөн. ШГС-ын Хэсгийн алба хаагчид Шивээговь сумын 1, 2-р багийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээлэл болон биечлэн яриа таниулга хийх, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргэж ажиллаа.

➤ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Зөрчлийн 6 гомдол мэдээлэл хүлээж авсанаас 4 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж жолоодох эрхийг 1 жилээр хасаж, нийт 6 жолоочийг 2.400.000 төгрөгөөр торгож, 1 гомдлыг зөрчлийн хэрэг нээн шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаатай баривчлуулсан. “Уусан бол бүү жолоод”, “Хяналт шалгалт”, “Мотоцикл-Хамгаалах малгай” зэрэг нэгдсэн арга хэмжээний хүрээнд хэсгийн алба хаагчидын хамтаар А0102 босоо тэнхлэгийн авто замын постонд үүрэг гүйцэтгэн, хяналт шалгалт хийн ажиллаж 602 тээврийн хэрэгсэл шалгаж зөрчилтэй явсан 68 жолоочийг 2.850.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, 35 жолоочийн зөрчлийг засуулж, “Торгууль нөхөн төлүүлэлт” арга хэмжээний хүрээнд нийт 16 жолоочийн 1.550.000 төгрөгийн торгуулийг нөхөн төлүүлж ажилласан.



Эрүүл мэндийн төв

❖ **Амбулаторийн үзлэг**

Энэ 06 дугаар сард нийтдээ 155 амбулаторийн үзлэг хийгдсэн бөгөөд үүнээс идэвхитэй хяналт 18, урьдчилан сэргийлэх үзлэг 99, нярайн гэрийн эргэлт 9, томуугийн үзлэг 15, ковидын шинжилгээ 0 тус тус хийгдсэн байна.

❖ **Түргэн тусламжийн дуудлагын тоо хэмжээ, төрөл**

Түргэн тусламжийн нийт 68 дуудлага хийгдсэний алсын дуудлага 4, ойрын дуудлага 64 ирсэн байна. Үүнээс том хүн 34, хүүхэд 34 дуудлага бүртгэгдсэн бөгөөд хөхний эрт илрүүлэгийн үзлэг 18, умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэг хийгдээгүй байна.

❖ Стационарийн үйл ажиллагаа

Энэ сард эмнэлэгийн төвд хэвтэн эмчлүүлэгчид нийт 32 байсан бөгөөд үүнээс дотор эрхтэнээр 26, хүүхэд 6, төрөлт 0, халдварт өвчнөөр хэвтэн эмчлүүлээгүй байна.

❖ Сургалт, сурталчилгаа

Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн боловсрол олгох рaгe хуудас болон шивээговь нэгдсэн зарын дээр ард иргэдэд эрүүл мэндийн мэдээ, нийгмийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан богино хэмжээний бичлэг зэргийг цаг алдалгүй оруулж ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хийгдсэн одоогийн байдлаар хүрэлцээтэй байна. 2023 оны сургалт сурталчилгаа төлөвлөгөөний дагуу мэдээ мэдээлэл, зөвлөмжийг цаг тухай бүрт нь олон нийтийн сүлжээгээр мэдээллэдэг.

МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ